

**ДИПЛОМАТ БОЛОН АЛБАН ПАСПОРТ ЭЗЭМШИГЧДИЙГ
ВИЗИЙН ШААРДЛАГААС ХАРИЛЦАН ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
БҮГД НАЙРАМДАХ КИПР УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Кипр Улсын Засгийн газар /цаашид “Хэлэлцэн тохирогч талууд” гэх/,

Хэлэлцэн тохирогч талуудын найрамдалт харилцааг бэхжүүлэхийг эрмэлзэн,

Дараахь зүйлийг харилцан тохиролцов. Үүнд:

1 дүгээр зүйл

1. Монгол Улсын болон Бүгд Найрамдах Кипр Улсын хүчин төгөлдөр дипломат болон албан паспорт эзэмшигч иргэд нь Хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт визгүй зорчиж болох бөгөөд тухайн улсын нутаг дэвсгэрт хил нэвтэрсэн өдрөөс эхлэн ер /90/ хүртэл хоногийн хугацаанд байх эрхтэй.

2. Хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт орших дипломат, худалдааны болон консулын төлөөлөгчийн газар, эсхүл олон улсын байгууллагад томилогдон ажиллах хүчин төгөлдөр дипломат болон албан паспорт эзэмшигч Монгол Улсын болон Бүгд Найрамдах Кипр Улсын иргэд нь томилолтынхоо хугацаанд Хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт визгүйгээр зорчиж, оршин сууж болно.

3. Энэ зүйлийн 2 дахь заалтад дурдсан хүмүүстэй хамт амьдрах хүчин төгөлдөр дипломат болон албан паспорттай гэр бүлийн гишүүд нь дээрх хүмүүсийн томилолтын хугацаанд Хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт визгүйгээр зорчиж, оршин сууж болно.

2 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд дурдсан хүмүүс Хэлэлцэн тохирогч нөгөө талын улсын хилээр нэвтрэхдээ тухайн улсын Засгийн газраас тогтоосон олон улсын шинжтэй хилийн боомтоор зорчино.

3 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч аль нэг тал улсынхаа аюулгүй байдлыг хангах, нийтийн дэг журам сахиулах, эсхүл нийтийн эрүүл мэндийг хамгаалах шалтгааны улмаас Хэлэлцэн тохирогч нөгөө талын иргэдийг өөрийн улсын хилээр нэвтрүүлэх, эсхүл нутаг дэвсгэртээ байлгахаас татгалзах эрхтэй. Түүнчлэн хүлээн авагч талын хууль тогтоомжийн дагуу эдгээр хүмүүсийг өөрийн нутаг дэвсгэртээ байлгах хугацааг богиносгох эсхүл цуцлах эрхтэй.

4 дүгээр зүйл

Энэхүү хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд дурдсан хүмүүс Хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт байх хугацаандаа тухайн улсын хүчин төгөлдөр хууль тогтоомжийг дагаж мөрдөх үүрэгтэй.

5 дугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч аль нэг тал нь улсынхаа аюулгүй байдлыг хангах, нийтийн дэг журам сахиулах, эсхүл нийтийн эрүүл мэндийг хамгаалах шалтгааны улмаас энэхүү хэлэлцээрийн үйлчлэлийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн түр зогсоож болно.

2. Хэлэлцэн тохирогч талууд дээрх шалтгааны улмаас аливаа хязгаарлалтын арга хэмжээ авсан тухайгаа болон хэлэлцээрийн үйлчлэлийг түр зогсоосон шалтгаан арилсан даруйд хязгаарлалтын арга хэмжээг зогсоосон тухайгаа дипломат шугамаа нэн даруй мэдэгдэнэ.

3. Энэхүү зүйлийн 1, 2 дахь заалт нь Хэлэлцэн тохирогч нэг тал энэхүү хэлэлцээрийн үйлчлэлийг Хэлэлцэн тохирогч нөгөө талаас түр зогсоосон үед түүнтэй адилаар хэлэлцээрийн үйлчлэлийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн түр зогсоох эрхийг хөндөхгүй.

6 дугаар зүйл

1. Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор Хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагууд хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө хүчин төгөлдөр дипломат болон албан паспортын загваруудыг дипломат шугамаар харилцан солилцоно.

2. Шинэ баримт бичиг нэвтрүүлэх, эсхүл хэрэглэж буй дипломат болон албан паспортод өөрчлөлт оруулах тохиолдолд Хэлэлцэн тохирогч талууд харилцан мэдэгдэх бөгөөд шинэ эсхүл өөрчлөлт орсон баримт бичгийн загваруудыг тэдгээрийн хэрэглэж эхлэхээс гуч /30/ хоногийн өмнө дипломат шугамаар хүргүүлнэ.

7 дугаар зүйл

1. Энэхүү хэлэлцээр нь Хэлэлцэн тохирогч талууд түүнийг хүчин төгөлдөр болгоход тавигддаг дотоодын шаардлагыг хангасан тухайгаа мэдэгдсэн ноот бичгийг харилцан солилцсон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү хэлэлцээрийг 5 жилийн хугацаатай байгуулав. Хэлэлцэн тохирогч аль нэг тал хэлэлцээрийг цуцлах хүсэлтээ ийнхүү цуцлахаас 6 сарын өмнө нөгөө талдаа дипломат шугамаар бичгээр мэдэгдээгүй бол Талууд хэлэлцээрийн хүчинтэй хугацаа дуусахаас өмнө ноот бичиг харилцан солилцох замаар хэлэлцээрийг 5, 5 жилийн хугацаагаар сунгаж болно.

3. Хэлэлцэн тохирогч талуудын энэхүү хэлэлцээрт оруулахаар харилцан тохиролцсон нэмэлт, өөрчлөлт нь Хэлэлцэн тохирогч талууд тухайн нэмэлт, өөрчлөлтийг зөвшөөрч буйгаа нотолсон ноот бичгийг харилцан солилцсон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4. Хэлэлцэн тохирогч аль нэг тал дипломат шугамаар бичгээр мэдэгдэх замаар энэхүү хэлэлцээрийг хэдийд ч цуцалж болно. Энэхүү хэлэлцээр нь тухайн мэдэгдлийг Хэлэлцэн тохирогч нөгөө тал хүлээн авсан өдрөөс хойших 90 дэх хоногоос цуцлагдсанд тооцогдоно.

Энэхүү хэлэлцээрийг Никоса хотноо 2011 оны 3 дугаар сарын 30-ны өдөр монгол, грек, англи хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Монгол, грек хэлээрх эх бичвэрүүдийн хооронд зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ**

**БҮГД НАЙРАМДАХ КИПР
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ**